

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

“Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хууль
2020.12.31

Дагаж мөрдөх огноо:

21 03 10

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

21 03 10

Байгууллагын нэр:

Гадаадын иргэн, харьяатын газар

Нэгжийн нэр:

Хангалт, үйлчилгээний хэлтэс
/Агентлагийн даргын 2021.03.10-ны өдрийн А/48 дугаар тушаалаар өөрчлөлт орсон/

Албан тушаалын нэр:

Цахилгаанчин

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Төрийн үйлчилгээ, ТҮ-7

Ажлын цаг:

Ажлын өдрийн 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Хан-Уул дүүрэг, Буянт-Ухаа дэнж, Гадаадын иргэн, харьяатын газрын төв байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Байгууллагын үйлчилгээний өдөр тутмын ажлыг удирдан зохион байгуулах, ажлын байр ашиглалтын хэвийн байдлыг хангах, ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, автомашин, техник, хэрэгсэл, аж ахуйн үйлчилгээний цэвэрлэгээ, тохижилтын асуудлыг стандартын түвшинд гүйцэтгүүлэх, хариуцах, хурал, зөвлөгөөний бэлтгэл ажлыг зохион байгуулах, ажилтнуудын хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны хэрэгжилтийг хангах, үр дүнг хэлтсийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1.Албаны байрны цахилгааны шугам ба тоног төхөөрөмжийг суурилуулах, ашиглалтыг хангах, засвар үйлчилгээг хийх.

2.Цахилгааны шугамын холболт, тоног төхөөрөмж, системийн ажиллагааны өдөр тутмын найдвартай ажиллагааг хангах, гарсан эвдрэл гэмтлийг цаг алдалгүй засварлах.


Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Байгууллагын цахилгаан хангамж түүний тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хариуцах;	Байрнуудын цахилгааны шугам тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагаа, засвар үйлчилгээ цаг тухайдаа хийгдсэн байна.	Г
	2.Цахилгаан хангамжийн болон шитны үйл ажиллагаанд өдөр тутам хяналт тавих аюулгүй хэвийн ажиллах нөхцөлөөр хангах;	Цахилгааны өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан байна.	Г
	3.Цахилгаанаар ажилладаг хэрэгсэл, тоног төхөөрөмж эвдэрсэн тохиолдолд эвдрэлийн шалтгааныг тогтоож засварлах, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн туслалцаа авах;	Эвдрэл гэмтлийг олж илрүүлэн, холбогдох арга хэмжээг түргэн шуурхай авсан байна.	Г
	4.Агааржуулалтын моторыг хуваарийн дагуу ажиллуулах.	Батлагдсан хуваарийн дагуу ажиллуулсан байна.	Г
2 дугаар зорилтын хүрээнд	1.Цахилгааны шугам тоног төхөөрөмжийг суурилуулах ашиглалтыг хангах, засварлах үйлчилгээг хийх;	Засвар үйлчилгээг цаг хугацаанд нь хийж гүйцэтгэсэн байна.	Г
	2.Цахилгааны шугамын эвдрэл, ослын үед засвар үйлчилгээг шуурхай хийх;	Аюулгүй ажиллагааны дүрмийг баримтлан засвар үйлчилгээг хийсэн байна.	Г
	3.Байгууллагын бүх агааржуулалтын шугамын засвар үйлчилгээ, хэвийн ажиллагааг хангах;	Байгууллагын агааржуулалтын систем доголдолгүй хэвийн ажилласан байна.	Г
	4.Цахилгааны хязгаарлалт хийсэн нөхцөлд дизель мотор ажиллуулах, түүнийг бэлэн байдалд байлгах, гэрээт засвар үйлчилгээнд хяналт тавих;	Тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж, байгууллагын үйл ажиллагаа хэвийн явагдсан байна.	Г

ГАЛГАА/ДЫН ИРГЭН, ХАРЬААТЭННИ АЗ. . .
ЭХ ХУВЬ *даал* *А/48* *дугаар*
ТУШААЛ

	5.Байгууллагын трансформаторын дэд станцын хуурай салгуурын үл хөдлөх контактаас эхлэн тэжээлийн ерөнхий кабель, ерөнхий самбар, группийн самбарууд, барилгын цахилгааны монтажууд болон гадна дотор талын гэрэлтүүлэг, тоног төхөөрөмжүүд тэдгээрийн ашиглалт, хамгаалалт, засвар үйлчилгээг бүрэн хариуцах.	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм, заавар зөрчигдөөгүй, систем доголдолгүй хэвийн ажиллана.	Г
	6.Байгууллагын засвар үйлчилгээ, тохижилт, зохион байгуулах арга хэмжээний засал чимэглэл хийх ажилд оролцох;	Холбогдох арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.	Г
Бусад үйл ажиллагаа	1.Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай, Архивын тухай хууль, байгууллагын "Хөдөлмөрийн дотоод журам" болон бусад эрх зүйн актыг мөрдөж ажиллах;	Хууль тогтоомж, дүрэм журмыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлсэн байна.	Г
	2.Эрхэлсэн ажлын чиг үүргийн хэрэгжилтийг бүрэн хариуцаж, зөрчил дутагдал гарсан тохиолдолд хариуцлага хүлээх;	Хууль тогтоомж, дүрэм журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.	Г
	3.Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж ажиллах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, стандартыг биелүүлэх;	Хууль тогтоомж, дүрэм журмыг үйл ажиллагаандаа мөрдөн зөрчил, дутагдал гаргалгүй ажилласан байна.	Г
	5.Удирдлагаас өгсөн хууль ёсны үүрэг даалгаврыг биелүүлэх;	Үүрэг даалгаврыг тухай бүр биелүүлж ажилласан байна.	Г
	6.Байгууллагаас зохион байгуулж буй олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй оролцох.	Арга хэмжээнд оролцсон байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Тусгай дунд болон мэргэжлийн сургууль төгссөн байх	
Мэргэжил	- Мэргэжлийн үнэмлэхтэй байх.	
Мэргэшил	- Мэргэшлийн зэрэгтэй байх.	
Туршлага	-	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	- цахилгааны эвдрэл гэмтлийг оношлох чадвартай байх; - шийдвэрийн шууд болон шууд бус үр дагаврыг дүгнэх;



ЭХ ХУВЬ

ТУШААЛ

Асуудал шийдвэрлэх	- албан үүргийнхээ дагуу хариуцах ажил үүргийг хууль, тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн гүйцэтгэх;
Багаар ажиллах	- ёс зүйгээр хамт олноо манлайлан үлгэр дуурайл үзүүлэх; - ажил хэргийн хувьд бүтээлч, санаачилгатай ажиллах; - байгууллагын үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг хамт олондоо итгүүлэн ойлгуулах, хэрэгжүүлэх;
Бусад	- ажил гүйцэтгэх, хэрэгжүүлэх.

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Гадаадын иргэн, харьяатын газрын дарга, Дэд дарга, Хангалт, үйлчилгээний хэлтсийн дарга, аж ахуйн менежер.

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Нийт:

Бусад харилцах субъект

1. Иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн байгууллага.

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаал:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА

..... Д. ДАВААНЯМ

2021 оны дугаар сарын-ны өдөр

1116126983 2712253

Албан тушаалын тодорхойлолт баталсан:

Байгууллагын нэр:

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР

Шийдвэрийн огноо: 21 03 10

Дугаар: ... А/48 ...

(тамга/тэмдэг)

Агентлагийн дарга

..... Н. УУГАНБАЯР

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР
ЭХ ХУВЬ 2021 оны А/48 дугаар
ТУШААЛ